



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 09 сарын 10 өдөр

Дугаар 8/54

Улаанбаатар хот

Г Намрын ээлжит техникийн хяналтын үзлэг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Автотээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, Засгийн газрын 2016 оны 213 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/817 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Тээврийн Үйлчилгээний газрын Дүрэм -ийн 2.5.3, 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний их, дунд, бага багтаамжийн автобус, троллейбус, ажилчдын автобус болон такси үйлчилгээний тээврийн хэрэгслийн намрын ээлжит Техникийн хяналтын үзлэгийг 2019 оны 09 дүгээр сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 22-ны өдрийг дуустал хугацаанд зохион байгуулж, техникийн хяналтын үзлэгт хамрагдах хуваарийг хавсралт ёсоор баталсугай.

2. Дээрх үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартад нийцүүлэн шуурхай зохион байгуулж, батлагдсан хугацаанд үзлэгт хамрагдаагүй болон тэнцээгүй тээврийн хэрэгслүүдийн мэдээллийг Улаанбаатар смарт карт ХХК-ийн Tbox програмд тухай бүрт нь оруулах, тэнцээгүй тээврийн хэрэгслийг тухайн өдөрт нь давтан оруулахгүй байх, үзлэгийн дүн мэдээг холбогдох байгууллага хэлтсүүдэд шуурхай, үнэн зөв хүргүүлж, холбогдох байгууллагуудыг мэдээллээр шуурхай ханган, Даргын зөвлөлийн хуралд 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн дотор танилцуулахыг Техникийн үзлэг, оношилгооны төв /Д.Галбадрах/-д үүрэг болгосугай.

3. Техникийн хяналтын үзлэгийн төвийн тоног төхөөрөмжийн үзлэг, урсгал засварт шаардагдах 3,696,000 /гурван сая зургаан зуун ерэн зургаан мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн ахлах нягтлан бодогч /Э.Эрдэнэтуюя-/ д зөвшөөрсүгэй.


4. Намрын ээлжит техникийн хяналтын үзлэгт нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх гэрээтэй аж ахуйн нэгж, байгууллагын тээврийн хэрэгслүүдийг батлагдсан хуваарийн дагуу шуурхай хамруулж, хяналт тавьж ажиллахыг Тээврийн хяналтын хэлтэс /З.Цэвээндорж/-т үүрэг болгосугай.

5. Нийтийн тээврийн бүртгэлийн санд бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийг тушаалаар батлагдсан хуваарыт хугацаанд багтаан холбогдох стандартын шаардлагуудыг бүрэн хангуулж, тээврийн хэрэгслийн өнгө үзэмж, цэвэрлэгээ, иж бүрдэл, замналын нэр, хаяг, зураглал, дугаар зэрэг нэмэлт шаардлагуудыг онцгой

анхаарч, техникийн хяналтын үзлэгт жигд, шуурхай хамруулахыг нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн байгууллагуудын удирдлагаад үүрэг болгосугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Орлогч даргын үүрэг гүйцэтгэгч /Д.Мөнхбаатар/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Ч САЙХАНБАЯР